

“ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04-р сарын 30-ны өдөр

№01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг
хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, “Дархан гурил тэжээл” ХК-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.21 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн саналын эрхтэй 553891 ширхэг хувьцааны эзэмшигчид буюу нийт хувьцааны 90,12 %-ийг эзэмшигчид хүрэлцэн ирсэн тул хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ш.ЭНХТӨР

**“ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04-р сарын 30-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи
ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Дархан гурил тэжээл” ХК-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4.9 дэх заалтуудыг тус тус удирдлага болгон “Дархан гурил тэжээл” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2023 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

НЭГ: “Дархан гурил тэжээл” ХК-ийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс “2022 онд төлөвлөгөөний дагуу үр дүнтэй ажилласан” гэсэн дүгнэлтийг Хавсралт-1 ёсоор баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ш.ЭНХТӨР

**“ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04-р сарын 30-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

**Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан
ТУЗ-ийн шийдвэрийг батлах тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Дархан гурил тэжээл” ХК-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4.9 дэх заалтуудыг тус тус удирдлага болгон 2023 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

НЭГ: “Дархан гурил тэжээл” ХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг баталсугай.

ХОЁР: “Дархан гурил тэжээл” ХК нь 2022 онд зардлаа нөхөж чадаагүй, алдагдалтай байгаа болон Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1, 47.1.2 дугаар заалтад заасан нөхцөлүүдийг хангахгүй байгаа тул хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ш.ЭНХТӨР